

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*



Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр: Улсын аварга тариаланч, Улсын аварга тариалнч хамт олонд олгох дурсгалын цом үйлдвэрлэн нийлүүлэх тендер

№	Барааны техникийн тодорхойлолтын үзүүлэлт, шаардлага	Санал болгож буй тодорхойлолт	Тайлбар
1	<p>Тавигдах ерөнхий шаардлага: Хөрс сийрүүлж байгаа сийрүүлүүрийн хутга бүхий суурьтай, сийрүүлсэн хөрснөөс ургасан тариаг дүрсэлсэн Цомыг гуулиар цутгаж өнгөлсөн байна. Хэрэв дахин давтагдашгүй патенттай бол патент ирүүлэх. Захиалагчийн заасан байрлалд өгсөн бичээсийг алдаагүй бичсэн байна.</p>		
2	<p>Гарал үүсэл: Монгол улс</p>		
3	<p>Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаяг: Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаягийг тодорхой бичиж ирүүлнэ.</p>		
4	<p>Үйлдвэрлэсэн он: 2024, 2025 оны аль нэг жил .</p>		
5	<p>Материал, хэмжээ, орц:</p> <ul style="list-style-type: none"> - Цомны өндөр – 38 см-ээс багагүй - Тариан түрүүний хэсэг <p>Тариан түрүү нь дөрвөн талт байна.</p> <p>Түрүүний урт – 17 см-ээс багагүй</p> <p>Түрүүний өргөн – 4 см-ээс багагүй</p> <p>Түрүүхэйн тоо- 29-өөс багагүй, сондгой тоотой байна.</p> <p>Сийрүүлүүр хошууны урт -11 см-ээс багагүй байх ба алтан шаргал өнгөтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Навчны хэсэг <p>Навчны тоо – 3 ш-ээс багагүй байна.</p> <p>Навчны урт – 12 см-ээс багагүй байна.</p> <p>Навчны өргөн – 2,5 см-ээс багагүй байна.</p> <p>Цомын суурийн хэсэгт алхан хээг дүрсэлнэ.</p>		

	<p>Суурийн өргөн – 11 см-ээс багагүй байна.</p> <p>Суурийн өндөр – 9 см-ээс багагүй байна.</p> <p>Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланчийн нэр, гардуулсан оныг гуулин ялтсан дээр сийлж бэхэлнэ.</p>		
6	<p>Савлалт, хадгалалт, хэрэглээ: Модоор хийсэн хайрцагтай байх ба нүүрэн талыг тунгалаг өнгөтэй, хайрцаг нь бариултай байна. Хайрцаг дээр салбарын онцлогийг харуулсан дүрслэл бүхий зурагтай байна</p>		
7	<p>Бараа хүргэх газар: Дархан-Уул аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.</p> <p>Захиалагч нэг бүрчлэн тоолон шалгаж хүлээн авна.</p>		
8	<p>Ачаа тээвэрлэх нөхцөл: Барааг гүйцэтгэгч өөрийн тээврээр хүргэж ирнэ. Тээвэрлэлийн үед байгаль, цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан үзэж, алдагдах, гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.</p>		
9	<p>Эх бэлтгэх: Гүйцэтгэгч дурсгалын цомын хэмжээ загвар хийцийн шаардлага хангасан зураг, бүдүүвч зургийн саналыг боловсруулж ирүүлнэ.</p>		
10	<p>Баталгаат хугацаа: 1 жил</p>		
11	<p>Нийлүүлэх хэмжээ: 33 ширхэг.</p>		



Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Улсын аварга тариаланч, Улсын аварга тариаланч хамт олонд олгох цом	33	ш	Монгол Улс, Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр баг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр	Гэрээ байгуулснаас хойш 10 хоногийн дотор	

